



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

“Эх, хүүхдийн эрүүл мэндийн төв” байгуулах тухай

Монгол улсын “Эрүүл мэндийн тухай” хуулийн 8.1.4 дэх заалт, “Эх, нярайн эрүүл мэнд” 2011-2015 оны стратегийн 1.3-ийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Булган аймгийн хэмжээнд үйлчлэх эх барих, эмэгтэйчүүдийн 70, хүүхдийн 50, нийт 120 ор бүхий “Эх, хүүхдийн эрүүл мэндийн төв”-ийг Дархан-Уул аймагт байгуулсугай.
2. “Эх, хүүхдийн эрүүл мэндийн төв”-ийг байгуулах төслийг эцэслэн боловсруулахыг Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар /С.Энхболд/, Эмнэлгийн тусlamжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Гончигсүрэн/-т, төвийг байгуулахад шаардагдах санхүүжилтийг олон улсын түншлэгч байгууллагуудад хандаж бурдүүлэхийг Санхүү хөрөнгө оруулалтын газар /Н.Түмэндээмбэрэл/, Гадаад хамтын ажиллагааны хэлтэс /Б.Янжмаа/-т, төвийн барилгын зургийн даалгаврыг боловсруулж, батлуулахыг Эрүүл мэндийн яамны Барилга захиалагчийн алба /н.Бат-Эрдэнэ/, Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газар /Э.Энхжаргал/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд /Ж.Цолмон/-д даалгасугай.



САЙД

С.Ламбаа

080060